**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 29 өдөр　　　　Дугаар А/125　　　　Баян-Өндөр сум

# Нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дугаар зүйлийн 54.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ЗГХЭГ/746 дугаар албан бичиг, нэгдсэн менежментийн тогтолцооны ISO 9001:2015, ISO 14001:2015, ISO 27001:2022 олон улсын стандартын 4 дүгээр бүлгийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд нэгдсэн менежментийн тогтолцоог хэрэгжүүлж байгаатай холбогдуулан нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Батлагдсан хамрах хүрээний дагуу нэгдсэн менежментийн тогтолцоог төлөвлөж хэрэгжүүлэхийг Чанарын багт даалгасугай.

ДАРГА　　　　　　　　Д.МӨНХБАТ

Албан хэрэгцээнд

6125070277

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 08 дугаар сарын 29...-ны өдрийн А/125 дугаар захирамжийн хавсралт

**Нэг.Бүтэц бүрэлдэхүүн**



**Хоёр: Үйл ажиллагааны хамрах хүрээ**

Тус үйл ажиллагааны хамрах хүрээ нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг зохион байгуулах үйл ажиллагааг хамарна. Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтад дараах ажлууд багтана. Үүнд:

2.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хурлын зөвлөл, төлөөлөгчид, хороод, Хурлын дэргэдэх зөвлөлүүд, ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах;

2.2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хурлын зөвлөл, төлөөлөгчид, хороод, Хурлын дэргэдэх зөвлөлүүд, ажлын хэсгүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

2.3.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хурлын зөвлөл, төлөөлөгчид, хороод, Хурлын дэргэдэх зөвлөлүүд үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх;

2.4.Хурал, Хурлын зөвлөл, хороодын хуралдааны бэлтгэл ажлыг хангаж хуралдуулах;

2.5.Хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулж байгаа төслийг хянаж, зохих журмын дагуу бэлтгэлийг хангуулах;

2.6.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын шийдвэрийг батлуулж ёсчлуулах;

2.7.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

2.8.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

2.9.Хуралдаанаар батлагдсан шийдвэрийг олон нийтэд ил тод мэдээлэх;

2.10.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг эрхлэх;

2.11.Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, шийдвэрлүүлэхээр уламжлах эргэж мэдээлэх, дүнг Хурлын дарга, холбогдох хороонд танилцуулах ажлыг зохион байгуулах;

2.12.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг хангах;

2.13.Монгол Улсын Засгийн газраас баталсан цалингийн сүлжээний дагуу цалинжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулах, хууль журмын дагуу ээлжийн амралт олгох ажлын гүйцэтгэлээр шагнаж урамшуулах, хариуцлага тооцох, нийгмийн баталгааг хангаж, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллах;

2.14.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, ажлын албаны төрийн албан хаагчдын Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт тавих, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар зөвлөмж өгөх, мэдээллийг холбогдох байгууллагад хуулийн хугацаанд мэдүүлж ажиллах.

**Гурав: Биет болон биет бус байрлалын хамрах хүрээ**

3.1.Биет байрлал

- Орхон аймгийн Нутгийн удирдлагын ордны 3 дугаар давхар (хасагдах байршил нь Орхон аймаг дахь Төрийн аудитын газар), В1 давхрын архивын өрөө, 1 дүгээр давхар зүүн талын жигүүр серверийн өрөө 118, агуулах өрөө 117.

3.2.Цахим хэлбэр